

АХМАДЫГ ҮЛ ОЙШООХ ҮЗЭГДЭЛ БУЮУ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ИЛРҮҮЛЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ОРОЛЦОО

Б.Ариунсанаа
Нийгмийн эрүүл мэндийн магистр

Хэдэн жилийн өмнө эмнэлгийн үйлчлүүлэгчийн хувьд үйлчилгээ хүсч асан миний бие нэгэн тасгийн үүдэнд ээлжээ хүлээн суухдаа хүүдээ зодуулан нүүрэндээ хүнд гэмтэл авсан гэх насжуу эмэгтэйг тэргэнцэртэй орж ирэхийг харсан тэр дүр зураг одоо хэр нь мартагддаггүй билээ.

Монгол улсад насжилтын үйл явц аль хэдийн эхэлснийг хэлж бичих болоод удаж байгаа ч энэ үг ямар утга агуулж буйг, цаашлаад улс орон насжилтад бэлтгэгдэнэ гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгох явц удаан байна. Европын орнуудад 40 жил үргэлжилсэн энэ үйл явц Японд 24 жилд бий болж нийгмийг цочирдуулж байсан бол Монгол орон 20 жилийн дараа насжилттай орны тоонд орох урьдчилсан таамаглал байна. Өөрөөр хэлбэл ахмад хүмүүсийг амьдрах хэвийн нөхцөлөөр хангах нь нийгмийн тогтвортой хөгжлийн үндсэн зорилгын нэг бөгөөд тэдний аж байдал, хэрэгцээнд онцгой анхаарал тавих нь төр засгийн гол үүрэг байдаг.²⁷⁴ Гэвч сүүлийн үед ахмадыг гэр бүл, олон нийт, нийгмийн зүгээс гадуурхах, үл ойшоох үзэгдэл нь геронтологийн ухаан, нийгмийн ажлын хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлын тоонд зүй ёсоор орж байна.

Тодорхойлолт, ангилал

Ахмадыг үл ойшоох, гадуурхах тухай асуудал одоогоос хориод жилийн өмнө олон нийтэд ил тод болж байсан буюу анх "эмгэн ээжээ балбах" гэсэн нэртэй нийтлэл Британийн Анагаах Ухааны сэтгүүлд нийтлэгдэн гарч байжээ. Ахмадыг үл тоомсорлох үзэгдлийг судлах ажил 1970-аад оны үеэс эхэлсэн ч албан ёсны тогтсон тодорхойлолт, онол арга зүйн бүрэн бус байдлаас судалгаа шинжилгээний ажил удааширсаар 1980-аад оны эхэн үед л нийгмийн шинжтэй тулгамдсан асуудал болохыг баталж, хүлээн зөвшөөрсөн байна.²⁷⁵ ДЭМБ-аас ахмадын хүчирхийлэл гэдэгт "Ахимаг насны хүнд итгэл төрүүлэхүйц харилцааны үед тэдэнд хохирол учруулах, гутралд оруулах нэг болон олон удаагийн давтамжит үйлдэл"²⁷⁶-ийг хамруулжээ. Ахмадын хүчирхийллийн олон хэлбэрийг судлаачид гаргасан байдаг ч түгээмэл тохиолдох хэлбэрүүдэд;

- *Биеийн хүчирхийлэл*

Настай хүнийг цохих, түлхэх, түлэх, хүчээр хорих гэх мэт санаатай болон санамсаргүйгээр биед нь ямарваа нэг гэмтэл, зовуурь, чадварыг нь доройтуулах бүх үйлдлүүдийг энэ ангилалд багтаадаг. Настай хүмүүст тохиолдсон биеийн хүчирхийллийн шинж тэмдгүүд нь залуу хүмүүсийнхтэй харьцуулахад ердийн хугарал, бэртэл гэмтлээс ялгагдахгүй байх нь элбэг бөгөөд эл байдлын улмаас нарийвчилсан судалгаа хийхэд хүндрэлтэй байдаг байна.

- *Сэтгэл зүйн хүчирхийлэл*

Настай хүнд айдас төрүүлсэн, тэднийг гутаан доромжилсон, басамжилсан утга бүхий үг хэллэг, үйлдлүүдийг энэ хэлбэрт багтаадаг. Тухайлбал, тэднийг загнах, жаахан хүүхэд мэт үзэх, хараах, хүнд хэцүү ажил даалгах, орчноос тусгаарлах, бусадтай харилцаа холбоонд орох боломжийг нь хаах, үл тоомсорлох, бусдаас хараат байх байдлыг хөхиүлэн дэмжих гэх мэт орно.

- *Санхүүгийн хувьд мэхлэх*

274 Ч.Дагвадорж. 2004. Нийгмийн хамгаалал: Онол арга зүй, туршлага, харьцуулалт. Улаанбаатар: Хөх Судар принтинг. х- 216

275 Spencer, C and Beaulieu, M. 1999. Older adults personal relationships and law in Canada: Legal, psycho-social and ethical aspects. pp-1

276 Jones, J.S et al. 1997. Elder mistreatment: National survey of emergency physicians. Annals of Emergency Medicine. 30:473-479

Энэ хэлбэрийн хүчирхийлэлд энгийн хулгай дээрмээс эхлээд мөнгөний нарийн зохицуулалтыг хамарсан өргөн хүрээтэй буюу хуримтлуулсан мөнгө, өв хөрөнгө, нөөц баялагт нь халдах, оюуны чадамж дорой байдлыг ашиглан үл ойлгогдох баримт бичиг, гэрээ мэтэд гарын үсэг зуруулах зэрэг үйл ажиллагаанууд багтана. Ахмад настны халамж, хамгааллын тогтолцоог цогц утгаар нь хөгжүүлсэн хөгжилтэй орнуудад, ахмадын нийгмийн халамж, хамгааллын картын нууц дугаарыг мэдэж улмаар ихээхэн хэмжээний мөнгө шамшигдуулах явдал сүүлийн жилүүдэд гарах болсон байна.²⁷⁷ Ахмад настныг санхүүгийн дарамтанд орсон эсэхэд хяналт тавих нь туйлын бэрхшээлтэй байдаг бөгөөд тэднийг асран халамжлагчид дээрх үйл ажиллагааг шаардагдах эмчилгээ, үйлчилгээний хөлсийг гаргуулахад гар бие оролцож буйг хооронд нь ялгаж салгах асуудал бүрхэг байдаг байна.

- *Үл ойшоох*

Энэ маягийн хүчирхийллийн хэлбэрт ахмад настай хүнийг халамжлах үүрэг хүлээсэн халамжлагчийн зүгээс эрүүл мэндийн, эмчилгээний, сэтгэцийн эрүүл мэндийн, хувийн ариун цэврийн халамжийг зохих түвшинд үзүүлэх, өлсөх, шингэн алдах зэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаас хамгаалах зэрэг функцийг үл гүйцэлдүүлэх зэрэг багтдаг. Хүчирхийллийн бусад хэлбэртэй харьцуулбал энэ хэлбэр нь төдийлөн чухалд тооцогдохгүй байж болох ч ахмад настны амь насанд аюул учруулах хүртэл үр дагаврыг авчрах ноцтой хэлбэр юм. Тухайлбал, хөдлөх чадваргүй хэвтрийн өвчтөнг тодорхой цаг хугацаанд эргүүлж, арьсыг хуурай байлгаагүйгээс арьсанд шархлалт үүсч, өвчтөний биеийн байдал хүндэрч идээт үрэвсэл (sepsis) болох явдал олонтаа тохиолддог байна.²⁷⁸ Ахмадын хүчирхийллийн асуудлыг судалдаг судлаачид, үл тоомсорлох явдал нь санаатай болон санамсаргүй хоёр хэв шинжтэй хэмээн ангилан үзэж, хэрэв асран халамжлагч ахмад настныг асрахад шаардагдах нөөц боломж, биеийн болоод сэтгэл зүйн эрч хүч, тэсвэр хатуужил, хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадвараар дутсан тохиолдолд *санамсаргүйгээр*, тодорхой зорилгын үүднээс халамж үзүүлэхгүй байх, түүнийг таслан зогсоохыг *санаатайгаар* үл ойшоож байна гэж үзэхийг санал болгожээ. Тухайлбал, өв залгамжлагч хэн байх нь тодорхой болсон үед ахмад настныг үхэлд яаруулах гэх мэт.

- *Бусад*

Ахмадын эсрэг хүчирхийллийн бусад хэлбэрүүдэд *эрхийг зөрчих* (нөхөр эсвэл эхнэр, бусад гэр бүлийн гишүүд, хувийн асрамжлагчид, үйлчилгээний ажилтнууд гэх мэт), *оргуулах* (асрамжийн төвөөс албадлагаар гаргах), *орхих* (асрамжийг залгуулан үзүүлэх боломжгүй нөхцөл байдалд ганцааранг нь бүр мөсөн орхих г.м) зэрэг хэлбэрүүд багтана.²⁷⁹

Баримт

Хөгжилтэй орнуудад ахмадын хүчирхийллийг нийгмийн тулгамдсан асуудлуудын нэгд зүй ёсоор тооцон, судалгаа шинжилгээний ажлыг эрчимтэй явуулдаг ажээ. Тухайлбал, АНУ-д жил бүр 2 сая ахимаг насны хүн ам хүчирхийллийн ямар нэг хэлбэрт өртдөг гэсэн дүнг судалгаагаар илрүүлсэн байна.²⁸⁰ Мөн түүнчлэн настай өвчтөнгүүд жилд дунджаар 5 удаа эмчийн үзлэгт хамрагддаг байхад хүчирхийллийн тохиолдлуудын зөвхөн 2 хувийг л илрүүлдэг ажээ. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн 60 буюу түүнээс дээш хувь нь өвчтөнөөсөө хүчирхийлэлд автсаныг илрүүлэх зорилгоор ямар нэг асуултыг асууж байсан удаагүй гэсэн хариулыг дээрх судалгаанд өгсөн байна. Мөн өөр нэгэн судалгаагаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ахмадын хүчирхийлэл гэдэгт анагаах ухааны үүднээс чухам юуг ойлгох, тэр ч бүү хэл дээрх үзэгдэл нийгэмд оршин байдаг гэдэгт (74%), яаралтай тусламж үйлчилгээний эмч нар хүчирхийллийн, нэн ялангуяа ахмадын хүчирхийллийн тохиолдлуудыг нарийн илрүүлэх боломжтой (58%), муж улсуудад золиос бологчдын хэрэгцээ, шаардлагыг хангах бүрэн нөөц боломж бий гэдэгт итгэдэггүй гэсэн хариултаудыг өгсөн байжээ.²⁸¹

277 Nerenberg, L.2006. Communities Respond to Elder Abuse. Social work in health. 46:5-33

278 Thobaben, M. 2001. Mistreatment of Elders by Family Members. Home care provider. pp. 112-3

279 Nerenberg, L.2006. Communities Respond to Elder Abuse. Social work in health. 46:5-33


280 Kennedy, R.D. 2005. Elder abuse and Neglect: The experience, knowledge, and attitudes of primary care physicians. Family Medicine. 37: 481-485

281 Jones, J.S et al. 1997. Elder mistreatment: National survey of emergency physicians. Annals of Emergency Medicine. 30:473-479

Энэ асуудал уламжлал, соёлын хүчин зүйл нийгмийн харилцаанд хүчтэй нөлөө үзүүлж байдаг Азийн орнуудад ч анхаарал татаж эхэлж байна. Тухайлбал, Оо нарын судалгаанд²⁸² хамрагдсан 15230 респондентуудын хувьд хүчирхийллийн түвшин бүх хэлбэрт 6.3 хувь (100.000 хүн тутамд) байсны сацуу сэтгэл зүйн хүчирхийлэл хамгийн түгээмэл тохиолддог байхад биеийн хүчирхийлэл хамгийн бага тохиолддог байна. Энэ нь уламжлал ёсоор өргөтгөсөн гэр бүлийг эрхэмлэдэг Солонгос мэт улсын залуу үеийнхэн энэ байдалд шүүмжлэлтэй хандаж, эцэг эхээсээ өрх тусгаарлаж, тусгаар амьдрах байдлаас эх үндэстэй буюу ахмад настанд гэр бүлийн зүгээс үзүүлэх асрамж, халамжийн асуудал тулгардаг байна.

Эрсдэлийн хүчин зүйлс

Ахмад настнууд ямар учраас хүчирхийлүүлж, гадуурхагдаж байдгийг онолын үүднээс тайлбарлахын тулд сэтгэл зүйн, нийгмийн, соёлын хүчин зүйлүүдийг авч үзэх шаардлагатай болдог. Учир шалтгааныг тайлбарлах олон онолууд байдгаас хамгийн түгээмэл тохиолддог нь;



Хайрцаг 1. Ахмадын хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлс

Хучирхийлэгчийн сэтгэцийн эмгэг /психопатологи/

Энэ төрлийн онолууд ахмад настныг халамжилж буй хүний сэтгэл зүйн хөгжлийн гажгийг хүчирхийллийн үндсэн шалтгаанд тооцдог. Хучирхийлэгч нь сэтгэцийн хувьд, зан үйлийн хувьд өөрчлөлттэй байдаг буюу тэдэнд архи, хар тамхины донтолт, бие хүний хөгжлийн хоцрогдол, сэтгэцийн самуурал, деменци, сэтгэцийн хожимдол гэх мэт шинж тэмдгүүд илэрдэг байна. Ахмадуудтай ажилладаг судлаачид, мэргэжилтнүүд энэ төрлийн онолыг маш хялбарт тооцох нь байдаг ч Волф нарын судалгаагаар²⁸³ ахмадыг асран халамжилдаг хүмүүсийн 31 хувь нь сэтгэцийн өвчний ямар нэг түүхтэй, 43 хувь нь донтолттой байжээ. Судалгаануудаас нийтлэг ажиглагдсан зүйл нь ахмад настанд асрамж үзүүлэгч нь ихэвчлэн гэр бүлийн гишүүдтэй харьцуулахад нийгэмшлийн

282 Oh, J et al. 2006. A study of elder abuse in Korea. International journal of nursing studies. 43: 203-214

283 Wolf et al. 1998. Older adults- an 11 year longitudinal study of adult protective service use. Journal of elder abuse and neglect. 9:89-91

хувьд дорой, нийгмийн харилцаагаар хязгаарлагдмал нэгэн байх (ажилгүй гэх мэт) магадлал өндөр байжээ.

- *Үе дамжсан хүчирхийлэл*

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл, эхнэр /нөхөр/-ийн хүчирхийлэл тухайн гэр бүлийн харилцаанд нэгэнт танил болж, үеэс үед дамжин илрэх үзэгдлийг багтаана.

- *Халамжлагчийн стресс*

Ахмад настанд асрамж, халамжийг үзүүлэх үүрэг хариуцлага нь угтаа стресс үүсгэх гол шалтгаан болж болох юм. Тухайлбал, О'Маллигийн судалснаар тохиолдлуудын 63 хувь нь золиос бологч асрамжлагчид стресс үүсгэх үндсэн шалтгаан байсныг илрүүлсэн байна.²⁸⁴ Түүний үзсэнээр ахмад настны зарим тэвчишгүй зан үйлүүд буюу байнгын уналт, дэмийрэл, шалдлах, үг хэлээр доромжлох гэх мэт зан үйлүүд нь халамжийн эрчийг бууруулж улмаар стресс үүсгэдэг байна. Мөн түүнчлэн стресс үүсэхэд нөлөөлөх гадаад хүчин зүйлс буюу халамжлагч ажилгүй байх, өөрийн эрүүл мэндийн таагүй байдал, доогуур орлого зэрэг нь хүчирхийлэлд нөлөөлдөг ажээ.²⁸⁵ (Хайрцаг 1)

- *Хамааралт байдал*

Ахмад настны бусдаас хамаарах хамаарал нь эрүүл мэнд доройтох, үйлдэл хийх чадвар улам муудахтай холбоотой байдаг буюу наад захын үйлдлийг бусдаар туслуулж хийх нь үл ойшоогдох шалтгаан болдгийг өвчтөний түүх харуулдаг байна. Харин зарим судлаачид, Лакс, Пиллемер²⁸⁶ нар ахмад настны эрүүл мэнд, чадварын дорой байдал нь хүчирхийлэл үүсэхэд ямар нэг хэмжээгээр нөлөөлдөг гэж үзсэн буюу тэд өөрсдийгөө хамгаалах, өмгөөлөх чадвараа алддагаас хүчирхийлэл газар авдаг гэж үзжээ.²⁸⁷

- *Халамж узуулж буй орчин*

Ахмадын хүчирхийлэлд нөлөөлөх бусад хүчин зүйлд ахмадыг нийгмийн харилцаанаас тусгаарлах, нэг орон байранд олуулаа амьдрах, халамжлагч ахмад настны хоорондын харилцаа холбоо зэрэг орно. Ахмад настанд хэн халамж үзүүлж байгааг мэдэх нь чухал юм. Учир нь нөхөр /эхнэр/ нь халамжилж буй тохиолдолд биеийн хүчирхийлэлд, харин насанд хүрсэн хүүхдүүдээрээ халамжлуулахад сэтгэл зүйн буюу үл ойшоох хандлага ажиглагддаг байна.

Илрүүлэлт ба урьдчилан сэргийлэл

Ахмадыг хүчирхийлэлд автахаас урьдчилан сэргийлнэ гэдэг нь нийгмийн дэмжлэгийн тогтолцоо, эмнэл зүйн асаргаа сувилгааны чанараас ихээхэн хамаарах²⁸⁸ бөгөөд эрсдэл бүхий өвчтөн, түүнийг халамжлагчийн хоорондын харилцаа, хүчирхийллийн үндсэн шалтгааныг илрүүлэхээс эхэлнэ.

Өвчтөнийг хүчирхийлэлд автсан эсэхийг илрүүлэхийн тулд;

- Өвчний түүхийг судалж, үзлэгт хамруулах

Ахмад настныг хүчирхийлэлд автсаныг илрүүлэх хамгийн эхний алхам бол эмчийн үзлэгт хамруулах явдал бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүсэх нь олшрох, үл ойлгогдох шалтгаанаар эмчилгээний цагийг хойшлуулах, эмчтэй хийх уулзалтанд ирэхгүй байх, шалтгаангүйгээр бэртэл, гэмтэл авах, тэдгээрийн тайлбар нь эмчийн үзлэгийн дүнтэй нийцэхгүй байх зэрэг шинжүүдэд анхаарлаа хандуулах хэрэгтэй.²⁸⁹ Мөн түүнчлэн биеийн хэсгүүдэд үзлэг, оношлогоог хийх хэрэгтэй.

284 <http://www.elderabusecenter.org/default.cfm?p=riskassessment.cfm>

285 Jones, J.S.1997. Elder Abuse and Neglect: Understanding the causes and Potential Risk Factors. American journal of emergency medicine. 15: 579-583

286 Lachs and Pillemer.1995.Abuse and neglect of elderly persons. The New England Journal of Medicine. 332: 437-443

287 Lachs, M.S et al. 1994. Prospective community-based pilot study of risk factors for the investigation of elder mistreatment. Journal of American Geriatric Society. 42: 169-173

288 Swagerty, D.L et al. 1999. Elder mistreatment. American Family Physician. 59: 2804-2808

289 Paris, C et al. 1995. Elder abuse and neglect: How to recognize warning signs and intervene. Geriatrics. 50: 47-53

<i>Биеийн хэсэг</i>	<i>Хүчирхийллийн шинж тэмдгүүд</i>
Толгойн хэсэг	Гэмтэл бүхий ус уналт, биеийн хүчирхийллийн бусад шинж тэмдгүүд, амны хөндийн бохирдол
Арьс	Шарх, сорви, түлэгдэл
Булчин, яс	Хугарал, гэмтэл
Мэдрэлийн	Шийдвэр гаргах чадвар, оюуны чадамж
Дотоод ариун цэвэр	Ариун цэвэр дорой сахих
Ерөнхий	Турах, шингэн алдах, зохион байгуулалтгүй байх

- Өвчтөний хандлага, харилцааг ажиглаж, нөхцөл байдалд үнэлгээ хийх

Ахимаг настай өвчтөний танин мэдэхүйн, биеийн, функциональ байдалд үргэлж хяналт тавьж байх шаардлагатай. (Хүснэгт 2) Мөн түүнчлэн орон сууц, санхүүгийн байдал, нийгмийн дэмжлэг туслалцаа, сэтгэл хөдлөл болон сэтгэл зүйн байдал, стрессоруудын тухай асууж, үнэлэхийн сацуу өвчтөн гэр бүлийн гишүүддээ хэрхэн хандаж байгааг болгоомжтой ажиглах хэрэгтэй.²⁹⁰ (Хүснэгт 3) Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн зүгээс ахмад настай өвчтөнтэй ганцаарчилсан ярилцлагыг хийхдээ оюуны чадамжийн дорой байдалд ч өвчтөнүүд өөрсдийн нөхцөл байдлын тухай сэтгэгдлийг илэрхийлэх чадвартай байдаг гэдгийг санаж байх нь чухал юм. Зарим тохиолдолд шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэгчтэй шүүмжлэлт бус байр сууринаас хандсан уулзалтыг зохион байгуулж болдог.

Хүснэгт 2. Өвчтөнд мэргэжлийн ажиглалт хийх

Өвчтөн гэр бүлийн гишүүдээс айсан шинжтэй байна
Өвчтөн асуултанд дурамжхан хариулна
Өвчтөнөөс авсан мэдээлэл гэр бүлийн гишүүдийн өгсөн мэдээлэлтэй зөрчилдөх
Гэр бүлийн гишүүд өвчтөнтэй бухимдуу харьцах, шаардлагатай тусламжаас татгалзах
Гэр бүлийн гишүүд төлбөрийн асуудалд санаа зовних
Гэр бүлийн гишүүд өвчтөний сайн сайхан байдалд бүхэлд нь бус, тодорхой нэг өвчинд санаа зовних

Хүснэгт 3. Эмч, эмнэлгийн мэргэжилтний зүгээс хүчирхийллийг илрүүлэх асуултауд

<i>Хүчирхийллийн хэлбэр</i>	<i>Үйлчлүүлэгчид тавих потенциал асуулт</i>
Биеийн хүчирхийлэл	Танд хэн нэгэн гар хүрч байсан удаатай юу?
Сэтгэл зүйн	Та хэн нэгнээс айж байна уу?
Бэлгийн	Таны зөвшөөрөлгүйгээр хэн нэгэн танд хүрч байсан уу?
Санхүүгийн	Та өөрөө ойлгоогүй ямар нэг баримт бичигт гарын үсэг зурсан уу?
Үл ойшоох	Та хамгийн сүүлд хэзээ хоол идсэн бэ?

- Интервенцийг сонгох

Ахмадын хүчирхийллийг илрүүлсэн тохиолдолд хуулийн, ёс зүйн хүрээнд хүлээсэн үүргээ мэдэх нь маш чухал байдаг. Нэн ялангуяа, эл асуудалтай шууд тулж ажиллах үйлчилгээ үзүүлдэггүй байгууллагад бэрхшээл тулгарч болох талтайг харгалзан үзэж зарим улс орон хуулийн хүрээнд зохицуулж өгсөн байдаг. Тухайлбал, АНУ-д хэрэв эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ахмадыг хүчирхийлэлд автсан гэдгийг илрүүлсэн тохиолдолд өвчтөний өмнөөс мэдэгдэл хийх хуулийн, ёс зүйн үүрэг хүлээсэн байдаг байна. Ахмадын хүчирхийлэлтэй гериатрикч, нийгмийн ажилтан, сувилагч, хууль зүйн, санхүүгийн байгууллагын төлөөлөгчдийн олон салбар ухааны мэргэжилтнүүдээс бүрдсэн багийн зорилго, чиглэлтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь үр дүнтэй болох нь практикаар батлагджээ. Мөн ахмадуудын өөрсдийнх нь санаачилгаар сайн дурын

290 Thobaben, M. 2001. Mistreatment of Elders by Family Members. Home care provider. pp.112-3

нөлөөллийн бүлгийг байгуулж, асран халамжлагчийг солих, өвчтөнийг шилжүүлэх арга ажиллагааг хэрэгжүүлэх нь ч үр ашигтайд тооцогддог.

Ахмад настангуудын оюуны болон биеийн хүчний чадамжийн доройтлыг байгалийн жамаар явагдах үзэгдэл буюу насжилт, гэр бүлийн хүчирхийллийг хувийн шинжтэй гэр бүлийн дотоод асуудал гэж үзэх олон нийт, нийгмийн хандлагаас болж хүчирхийллийн хор уршгийг үл ойшоох явдал нь тэднийг үл хайхрах байдал, хүчирхийллийг нарийвчлан тодорхойлоход саад учруулдаг.²⁹¹ Мөн түүнчлэн хүчирхийллийн асуудал нь эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийн ажлын чиглэл бус, тэдэнд энэ чиглэлийн мэргэшил дутмаг, цаг зав байхгүйгээс ахмадын хүчирхийллийг илрүүлэхэд хүндрэлтэй ажээ.

Гэсэн хэдий ч энэ асуудлын талаар эмч, эрүүл мэндийн ажилтнууд, цаашлаад олон нийт нийгэм, шийдвэр гаргагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх нь нөхцөл байдалд эерэг үр нөлөө авчирдаг болохыг Голландад хийгдсэн судалгаа харуулжээ. Судалгаанд хамрагдагсдын 70 хувь нь өөрсдийг нь үл ойшоох байдал, хүчирхийллийг өөрсдөө эсвэл хэн нэгний тусламжтайгаар таслан зогсоох чадвартай болсон байна.²⁹²

291 Thobaben, M. 2001. Mistreatment of Elders by Family Members. Home care provider. pp.112-3

292 Smit, J.H et al. 1998. Elder abuse in the community: prevention and consequences. Journal of American Geriatric Society. 46: 885-888